

\*\*\*\*\*

TRANSACTION REPORT

29-APR-2014 10:17

FOR:



SEND

МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

DATE	START	RECEIVER	PAGES	TIME	NOTE
29-APR 2014	10:10	155	1	38"	JAM Чойбало

\*\*\*\*\*

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 222 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дорнод аймгийн нутаг дэвсгэрт олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүд нутгийн захиргааны байгууллагатай нягт уялдаа холбоотой ажиллах, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, санаачилгын ач холбогдлыг сурталчлах, олон нийтэд мэдээлэх, аймгийн дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Татварын хэлтсийн дарга
- Гишүүд:
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн уул уурхай хариуцсан мэргэжилтэн
  - Аймгийн Байгаль орчны газрын дарга
  - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
  - “Петрочайна дачин Тамсаг” ХХКомпани
  - “Эмээлт майнз” ХХКомпани
  - “Адуунчулуун” ХХКомпани
  - Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрын хөдөлгөөн
  - Улс төрийн боловсролын академи
  - Дорнод Монголын нутгийн иргэдийн Байгаль хамгаалах холбоо

2.Сумын Засаг даргын дэргэд ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх сумын дэд зөвлөлийг, сумын Орлогч даргаар ахлуулан төрийн байгууллагын төлөөлөл, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, байгаль орчин, иргэний нийгмийн эвслийн төлөөллийг бүрэн хамруулан байгуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Л.ХИШИГТОГТОХ

